

**ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД
СААД УЧРУУЛАХ, ЗАЙЛСХИЙХ ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ БА ШИЙДВЭРЛЭЛТ**
**CRIMINAL OFFENSES RELATED TO THE OBSTRUCTION OR EVASION OF CIVIL
COURT JUDGMENT ENFORCEMENT: INCIDENCE AND RESOLUTION**

С.Бямба-Эрдэнэ

*Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн багш, ахмад
ORCID ID: 0009-0005-6434-4181*

Б.Сумъяабазар

*Дотоод хэргийн их сургуулийн Шинжлэн магадлах ухааны сургуулийн
Криминалистикийн шинжилгээний тэнхимийн багш, цагдаагийн ахмад*

Товч агуулга: Монгол Улсын иргэн зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр буруутай этгээдийг шүүхэд мэдүүлж, гомдол, нэхэмжлэл гарган хандах эрхтэй бөгөөд иргэний эрх зүйн хариуцлагын хүрээнд эд баялагтай холбоотой зөрчигдсөн эрхийг зөвхөн иргэний хэргийн шүүх шийдвэрлэж, шүүхийн шийдвэр гарч, хуулийн хүчин төгөлдөр болсон нөхцөлд буруутай этгээдэд хохирогч буюу нэхэмжлэгчийн хохирлыг заавал төлөх үүрэг хүлээдэг. Шүүхийн шийдвэр бүр заавал биелэгдэх шинжийг агуулж байдаг тул сайн дураар төлбөр төлөхөөс зайлсхийвэл төрөөс албадан гүйцэтгэх журмаар шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулна. Энэхүү өгүүллийн хүрээнд судлаачийн зүгээс албадан гүйцэтгэх буюу иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хариуцагч шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх гэмт хэрэг үйлдсэн гэмт хэргийн шийдвэрлэлтийн талаарх судалгааг толилуулах болно.

Түлхүүр үг: Иргэний хэргийн шүүхийн шийдвэр, албадан гүйцэтгэх ажиллагаа, эрүүгийн хариуцлага, төлбөр төлөгч.

Abstract: A citizen of Mongolia has the right to file a complaint or claim with the court against the liable party in order to restore their violated rights. Within the framework of civil legal liability, disputes concerning property-related rights are resolved exclusively by civil courts. Once a court decision is made and becomes legally binding, the liable party is obligated to compensate the damage suffered by the claimant. Since all court decisions are binding and enforceable, if the liable party refuses to comply voluntarily, the state will ensure the enforcement of the decision through compulsory execution procedures. This article presents a study conducted by the author regarding the criminal cases involving defendants who have obstructed or evaded the enforcement of civil court decisions during the compulsory execution process.

Keywords: Civil court decision, Enforcement proceedings, Criminal liability, Debtor

Үндсэн хэсэг

Монгол Улсын нэрийн өмнөөс гаргасан Иргэний хэргийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын гишүүд биелүүлэх үүрэгтэй.

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага гэдэгт хуулийн этгээдийн үндсэн шинжийг агуулдаггүй хүмүүсийн болон хуулийн этгээдүүдийн нэгдэл байж болно гэж иргэний хуулийн шинжлэх ухааны тайлбарт тусгасан байдаг. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар (бичиг, 2015). (хүрээлэн, 2021, хууд. 28)

“Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь Иргэний хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэгт зааснаар хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар, мөн хуулийн 143 дугаар зүйлийн 143.3 дахь хэсэгт зааснаар сууц өмчлөгчдийн холбоо, мөн хуулийн 281 дүгээр зүйлийн 281.1. дэх хэсэгт заасан тодорхойлсон бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл хамаарна. Хариуцлагыг тухайн хуулийн этгээдийн эрхгүй байгууллага бус гишүүд нь хариуцлага хүлээдэг онцлогтой. Мөн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон үеэс заавал биелэгдэх шинжийг агуулдаг” (эмхэтгэл, Төрийн мэдээлэл, 2002).

Харин “ШШГБ-ын нийт алба хаагчдыг нийтлэг байдлаар хамааруулж алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг тухайн иргэн, хуулийн этгээд үл биелүүлэх эсхүл шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулбал хуульд заасан хариуцлага хүлээлгэх талаар тусгайлан зааж хуульчилсныг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, эсхүл хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан хүн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” (эмхэтгэл, Төрийн мэдээлэл, 2017) гэж зааснаас харж болно.

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх гэмт хэргийн талаар өгүүлэхийн өмнө ялын туйлын, ялын харьцангуйн, ялын дундын буюу либерал гэсэн 3 онолын талаар өгүүлнэ.

1. “Ялын туйлын онол- нэрт эрдэмтэн И.Кант, Г.Гегел нарын үндэслэн боловсруулсан туйлын буюу ялын бодлогын үнэмлэхүй хандлага гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд түүний учруулсан хохирол, гэмт хэргийн шинж, хэр хэмжээг харгалзан тэдгээрт яг тохирсон ялыг онооход чиглэгддэг үзэл баримтлал юм” (Ц.Мөнхбат, 2020).
2. “Ялын харьцангуйн онол- нэрт эрдэмтэн П.А.Файербах, Ф.Ф.Лист нарын үндэслэн боловсруулсан уг онолоор бол ял нь ялтныг залхаан цээрлүүлэх бус, нийгэмшүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэдэг гэж заасан. Энэ онолыг зорилгоор нь дараах 4 хэсэгт ангилдаг” (Ц.Мөнхбат, 2020).
 - “Эерэг ерөнхий урьдчилан сэргийлэлт-Олон нийтийн эрх зүйн ухамсар, итгэлийг бэхжүүлэх” (Ц.Мөнхбат, 2020).
 - “Сөрөг ерөнхий урьдчилан сэргийлэлт-Олон нийтийг гэмт хэрэг үйлдэхээс болгоомжлох ухамсар бий болгох” (Ц.Мөнхбат, 2020),
 - “Эерэг тусгай урьдчилан сэргийлэлт-гэмт хэрэгтнийг хүмүүжүүлэх” (Ц.Мөнхбат, 2020),
 - “Сөрөг тусгай урьдчилан сэргийлэлт-олон нийтийг гэмт хэрэгтнээс сэргийлэн тусгаарлах” (Ц.Мөнхбат, 2020).
3. “Ялын дундын буюу Либерал онол- туйлын болон харьцангуйн онолын аль алиных нь сул талыг үгүйсгэн хязгаарлах замаар аль алинаас нь дэвшилтэд үнэт зүйлийг хослуулан нэгтгэж авсан нийлмэл шинжтэй либерал үзэл баримтлал юм. Энэхүү онол нь ял бол залхаан цээрлүүлэх шинж бүхий албадлагын арга хэмжээ болохыг хүлээн зөвшөөрдөггүй хэдий ч туйлын онолын “Гэмт хэрэгтний үйлдсэн хэрэгт нь оноох ял тэнцүү байх”, харьцангуйн онолын Ял нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх зорилготой албадлагын арга хэмжээ гэсэн үзэл санааг өөртөө багтаасан байдаг (Ц.Мөнхбат, 2020, хууд. 19).

“Германы нэрт эрдэмтэн Э.Хилгендорф ялын онолын чиг хандлагад харьцангуй хосолсон буюу үнэт зүйлсийн уян хатан чиг хандлага бүхий үзэл баримтлал зайлшгүй болсныг тэмдэглэсэн байх бөгөөд тэрээр бичихдээ “Германы эрүүгийн хууль нь үнэмлэхүй ба харьцангуй онолын аль нэгийг даган мөрддөггүй, харин энэхүү нэгтгэсэн

нэгдмэл онолыг мөрдлөг болгодог ба хуулиар заасан хэм хэмжээнүүд нь аливаа гэмт үйлдэхүйг залхаан цээрлүүлэх үзэл санаан дээр ч, мөн урьдчилан сэргийлэх зорилго дээр ч тулгуурладаг байна. Хэрэг дээрээ ингэж нэгтгэн хэрэглэх нь олон онолын сул тал юм уу зөвхөн нэг талыг барьсан шинжийг нөгөөгөөр нь нөхөн тэнцвэржүүлэх давуу талтай юм. Ингэж харьцангуй онол нь шийтгэлийг нийгмийн зорилго болгон харуулж байхад үнэмлэхүй онол нь шийтгэлийг уг хэргийн хүндийн хэмжээгээр ял шийтгэлийн хэмжээг заан хязгаарлаж өгөх бүрдүүлэх онол болон илэрч байна” (Э.Хилгендорф & Д, 2015, хууд. 19) гэжээ.

Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх хүсэлгүй, боломжгүй байгаа хариуцагчийн хүсэл зоригоос үл хамааран зөвхөн нэхэмжлэгчийн хүсэл зоригоос хамаарч шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх захирамж, гүйцэтгэх хуудас бичигдэж албадлага хэрэглэх үндэслэл бүрддэг.

“УИХ-аас 2015 онд баталсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21 дүгээр бүлгийн Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх” гэмт хэргийг мөн хуулийн 21.7 дугаар зүйлд тусгаж хуульчилсан байдаг” (эмхэтгэл, 2015).

“ЭХТА-ийн 21.7.1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах зорилгоор хөрөнгийн мэдүүлгээ зориуд буруу гаргасан, эд хөрөнгөө нуун дарагдуулсан, бусдад шилжүүлсэн, үрэгдүүлсэн, оршин суух хаягаа өөрчилсөн, дүр эсгэн биелүүлсэн, битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан хөрөнгийг дур мэдэн захиран зарцуулсан, дүр үзүүлсэн гэрээ байгуулсан бол,

- ✓ 2700 нэгжээс 5400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,
- ✓ Эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах,
- ✓ Эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” (эмхэтгэл, 2015) гэж сонгох санкцитайгаар зохицуулсан байдаг.

Энэ гэмт хэргийг үйлдэгч субъектийг зөвхөн төлбөр төлөгч-иргэн, төлбөр төлөгч-хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, “давуу эрхтэй хувьцаа эзэмшигчид” хамааруулж ойлгоно.

Тухайн хуулийн этгээдэд гүйцэтгэх удирдлага томилогдоогүй, эсхүл гүйцэтгэх удирдлагыг хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар чөлөөлсөн тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцааны дийлэнх хэсгийг эзэмшиж байгаа иргэн хуулийн этгээдийг төлөөлнө.

Энэ хэсэгт иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн талаарх судалгааг өгүүлж, гэмт явдлын шалтгаан нөхцөлийг судлахыг эрмэлзлээ.

Цагдаагийн байгууллага: “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх” гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг Цагдаагийн байгууллага явуулах бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээлсэн гомдлоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж төлбөр төлөгчийн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгадаг (эмхэтгэл, 2015).

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас Цагдаагийн байгууллагад хандан төлбөр төлөгчийн шүүхийн шийдвэр биелүүлэхгүй байгаа үйлдэл, эс үйлдэхүйд холбогдуулан гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар холбогдох нотлох баримтыг хүсэлтийн хамт гарган өгч хамтран ажиллах нь түгээмэл байна. Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хэмжээнд 2020-2023 оны байдлаар Цагдаагийн байгууллагад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас төлбөр төлөгчийн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар хандсан тоон мэдээллийг судлан үзэхэд:

№	Хүлээн авсан гомдол, мэдээллийн тоо	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг прокурорт хүргүүлж, прокурор хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан.	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх саналыг прокурорт гарган прокуророос хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгасан	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн хугацаанд прокурор хэрэг нээхээс татгалзсан	Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан
2020	56	34 /60.71%/	22 /39.28%/	20 /35.71%/	2 /3.57%/
2021	26	18 /69.23%/	8 /30.76%/	8 /30.76%/	0
2022	40	13 /32.5%/	27 /67.5%/	26 /65%/	1 /0.25%/
2023	30	9 /30%/	21 /70%/	21 /70%/	0
Нийт	152	74 /48.68%/	78 /51.31%/	75 /49.34%/	3 /1.97%/

Хүснэгт. № 1. Цагдаагийн байгууллагад хандсан гомдлын шийдвэрлэлт

Монгол Улсын хэмжээнд 2020-2023 оны хооронд төлбөр төлөгчийн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар Цагдаагийн байгууллагад нийт 152 төлбөр төлөгчид холбогдох гомдол, мэдээллийг хүргүүлж, үүнээс 74 буюу 48.68 хувьд нь мөрдөгчөөс хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг хяналтын прокурорт хүргүүлжээ.

Харин дээр дурдсан 152 гомдлоос 78 буюу 49.34 хувьд хэрэг бүртгэлтийн хэргийг нээж шалгасан байна. Мөн нийт гомдлоос мөрдөгч 75 буюу 49.34 хувьд нь эрүүгийн хэрэг нээхээс татгалзаж, нийт гомдлын дөнгөж 3 буюу 1.97 хувьд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, яллагдагчаар татсан байгаа энэ төрлийн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэлд мөрдөгч маш цөөн тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэж байгаа нь харагдлаа.

Энэ бол шийдвэр гүйцэтгэгчийн Цагдаагийн байгууллагад ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар хандсан хүсэлт, холбогдох нотлох баримтыг хариуцсан мөрдөгчийн зүгээс шалган үзээд гэмт хэргийн шинжгүй, бүрэлдэхүүнгүй гэх үндэслэлээр харьяа Прокурорын газрын хяналтын прокурортоо эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналаа хүргүүлж хэргийг шийдвэрлэдэг нөхцөл байдалтай шууд холбогдоно.

Төлбөр төлөгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Цагдаагийн байгууллагад хандсан хугацаанд шүүхийн шийдвэрт заасан төлбөр төлөгдсөн байдал. Монгол Улсын хэмжээнд 2020-2023 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас төлбөр төлөгчийн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар 253 хүсэлтийг Цагдаагийн байгууллагад гаргасан бөгөөд энэ хугацаанд шүүхийн шийдвэрт заасан төлбөрийг бүрэн төлсөн 9 тохиолдол бүртгэгджээ.

Хүснэгт № 2. (Я.Батгэрэл, 2024, хууд. 123)

№	Эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр хандсан	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	Эрүүгийн хэрэг үүсгэсэн	Хянагдаж байгаа	Шүүхээс шийдвэрлэсэн	Төлбөрөө төлж барагдуулсан	ШШГБ гомдлоо буцаан татсан
2020	57	50 /87.8%/	1	0	1	5	1
2021	61	57 /93.4%/	0	0	0	4	0
2022	48	48 /100%/	0	0	0	0	0
2023	87	70 /80.4%/	0	17	0	0	0
Нийт	253	225	1	17	1	9	1
		88.9%				3.55%	

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хандсан хугацаанд зарим төлбөр төлөгч нар шүүхийн шийдвэрт заасан төлбөрийг бүрэн төлсөн байгаа нь нийт гомдлын 3.55 хувийг

эзэлж байгаа боловч эрүүгийн хариуцлага үр дүнтэй арга хэмжээний нэг гэдгийг илэрхийлж байна.

Прокурорын байгууллага: “Прокурорын бүрэн эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт зааснаар “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно, Прокурорын тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих, мөн хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих, мөн хуулийн 17 дугаар зүйлд зааснаар прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралд оролцох, мөн хуулийн 22 дугаар зүйлд зааснаар прокурор ял эдлүүлэх ажиллагаанд оролцох, хяналт тавих бүрэн эрхийг тус тус хуульчилсан” (эмхэтгэл, Төрийн мэдээлэл, 2017).

Түүнчлэн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцоно гэж заасны дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьж ажилладаг” (эмхэтгэл, Төрийн мэдээлэл, 2017) билээ.

УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгээс Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсэгт заасан гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн талаарх статистик мэдээг 2020-2023 оны хооронд судлан үзэхэд:

№	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэрэг	Шинээр нээсэн хэрэг бүртгэлтийн хэрэг	Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	Эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татсан
2020	93	37 буюу 39.78%	56 /60.22%/	3 буюу 3.22%
2021	53	27 буюу 50.94%	26 /49%/	1 буюу 1.88%
2022	54	36 буюу 66.66%	18 /33.33%/	0
2023	66	35 буюу 53%	31 /49.96%/	1 буюу 1.51%
Нийт	266	135 буюу 50.75%	131 буюу 49.25%	5 буюу 1.87%

Хүснэгт № 3. Нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, шийдвэрлэсэн байдал

“Монгол Улсын хэмжээнд Прокурорын байгууллагаас 2020-2023 оны хооронд нийт 266 төлбөр төлөгчид холбогдох гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулж, үүнээс 135 буюу 50.75 хувьд нь шинээр хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 49.25 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэжээ” (Я.Батгэрэл, 2024, хууд. 131).

Харин дээр дурдсан 266 гомдлоос 5 буюу 1.87 хувьд нь прокуророос төлбөр төлөгчийг яллагдагчаар татсан байгаа энэ төрлийн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэлд прокуророос маш цөөн тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэж байгааг илэрхийлнэ.

Шүүх: “Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно” (эмхэтгэл, Төрийн мэдээлэл, 1992) гэж заасан байдаг. Мөн “Шүүхийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэгт зааснаар “Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд зориуд саад учруулсан этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” (эмхэтгэл, Төрийн мэдээлэл, 2021) гэж заасан байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс хариуцлага оногдуулсан байдлыг 2017-2025 оны хооронд судлан үзэхэд анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн 15 эрүүгийн хэрэг, давж заалдах шатны болон дээд шатны шүүхийн тус бүр 5 эрүүгийн хэрэг, нийт 25 шийдвэрт судалгаа хийж үзлээ. Тухайлбал,

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн судалгаа. “Анхан шатны шүүхийн бүрэн эрхийг Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 30.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Хуулиар харьяалуулсан хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх” (эмхэтгэл, Төрийн мэдээлэл, 2021) гэж заан тодорхойлжээ.

“Монгол Улсын хэмжээнд /2017-2025/ 2017 оноос 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.7 дугаар зүйлд заасан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх” гэмт хэргийг Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн байдлыг Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүж судлан үзэхэд 15 шийтгэх тогтоол” (сан, 2017-2025) байсан.

№	Шүүхийн харьяалал	Огноо, дугаар	Гэмт хэргийн зүйлчлэл ЭХТА-ийн 21.7.1, оногдуулсан ял, албадлагын арга хэмжээ
1.	Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2017.08.10 № 301	2.7 сая төгрөгөөр торгох ял шийтгэсэн
2.	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2018.05.08 № 647	6 /зургаа/ сарын хугацаагаар хорих ял шийтгэсэн.
3.	Баян-Өлгий аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2018.08.01 №111	3 сая төгрөгийн торгох ял шийтгэсэн.
4.	Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2018.10.19 № 190	Хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон.
5.	Хөвсгөл аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2018.10.22 № 292	Хорих ял оногдуулахгүйгээр 1 /нэг/ жилийн хугацаагаар тэнсэх албадлагын арга хэмжээ оногдуулсан.
6.	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2018.12.28 № 18	2.8 сая төгрөгөөр торгох ял шийтгэсэн
7.	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019.07.29 № 516	2.7 сая төгрөгөөр торгох ял шийтгэсэн
8.	Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2020.05.18 №86	2.7 сая төгрөгөөр торгох ял шийтгэсэн
9.	Баянхонгор аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2020.09.24 №321	Хорих ял оногдуулахгүйгээр 1 жилийн хугацаагаар тэнсэж, үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ оногдуулсан.
10.	Баянхонгор аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2021.05.20 №135	1 жилийн хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэсэн
11.	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2021.09.16 №498	2.7 сая төгрөгөөр торгох ял шийтгэсэн
12.	Архангай аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2022.10.04 №257	2.7 сая төгрөгөөр хорих ял шийтгэсэн
13.	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын шүүх	2024.02.20 №29	Хэрэгсэхгүй болгож цагаатгасан

14.	Өмнөговь аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2024.06.25 №97	6 /зургаа/ сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэсэн.
15.	Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2024.11.14 №204	3 сая төгрөгийн торгох ялаар шийтгэсэн.

Одоогийн байдлаар үүргийн гүйцэтгэлийг үл хөдлөх эд хөрөнгийн барьцаагаар хангуулж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт холбогдох иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх гэмт хэргийг шүүхээр хянан хэлэлцсэн тохиолдол бүртгэгдээгүй, гараагүй байна.

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн судалгаа. “Давж заалдах шатны бүрэн эрхийг Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 29.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хуульд заасны дагуу анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэх” (эмхэтгэл, Төрийн мэдээлэл, 2021) гэж тодорхой заасан байдаг.

“Монгол Улсын хэмжээнд /2017-2025/ 2017 оноос 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.7 дугаар зүйлд заасан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх” гэмт хэргийн шийдвэрлэлтийг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс хянасан байдлыг Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүж судлан үзэхэд 6 магадлал” (сан, 2017-2025) байсан.

№	Шүүхийн харьяалал	Огноо, дугаар	Давж заалдах гомдлыг шийдвэрлэсэн байдал
1.	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	2018.07.05 № 629	Баянзүрх дүүргийн ЭХАШШ-ийн 2018.05.08-ны өдрийн 647-р шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, В.Г-т холбогдох эрүүгийн хэргийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хянан хэлэлцүүлэхээр Баянзүрх дүүргийн ЭХАШ-ны шүүхэд буцаасан.
2.	Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	2018.07.05 № 24	Баян-Өлгий аймаг дахь сум дундын ЭХАШ шүүхийн 2018.08.01-ний өдрийн 111 дугаартай шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, шүүгдэгч Х.Х-ын давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгосон.
3.	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	2018.12.20 № 1128	Налайх дүүргийн ЭХАШШ-ийн 2018.10.19-ний өдрийн 190-р шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, Ч.Хд холбогдох эрүүгийн хэргийг дахин хэлэлцүүлэхээр Налайх дүүргийн ЭХАШ-ны шүүхэд буцаасан.
4.	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	2019.10.08 № 1001	Налайх дүүргийн ЭХАШШ-ийн 2019.08.14-ний өдрийн 111-р шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 2 дахь заалтыг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалт, 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтад зааснаар Ч.Х-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, түүнийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрүүгийн хариуцлагаас чөлөөлсүгэй.” гэж өөрчилсөн.
5.	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	2025.02.05 № 199	Налайх дүүргийн ЭХАШШ-ийн 2024.11.14-ний өдрийн 204-р шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн: 3 дахь заалтад 3,000,000 төгрөгийн торгох ялыг 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр тогтоож, ...” гэснийг, “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.3 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэгт зааснаар шүүгдэгчид оногдуулсан 3,000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 3,000,000 төгрөгийн торгох ялыг 90 хоногийн дотор төлүүлэхээр тогтоож өөрчилсөн.

Дээрх хүснэгтээс харвал Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс 2017 оноос 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн байдлаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.7 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт холбогдох нийт 5 шийтгэх

тогтоолыг хянажээ. Үүнээс шийтгэх тогтоолыг өөрчилсөн 2, шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, анхан шатны шүүхэд буцаасан 2, шийтгэх тогтоолыг хэвээр үлдээсэн 1 тохиолдолд бүртгэгдсэн байна.

Эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүхийн судалгаа. “Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ” (эмхэтгэл, Төрийн мэдээлэл, 1992) гэж заасан байдаг.

“Монгол Улсын хэмжээнд /2017-2025/ 2017 оноос 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.7 дугаар зүйлд заасан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх” гэмт хэргийн шийдвэрлэлтийг Эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүхээс хянасан байдлыг Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүж судлан үзэхэд 5 тогтоол” (сан, 2017-2025) байсан.

№ Тогтоолын огноо, дугаар Дээд шүүхээс гомдлыг шийдвэрлэсэн байдал

1.	Дээд шүүхийн тогтоол 2018.09.05 № 325	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 629 дүгээр магадлалын тогтоох хэсгийн 2 дахь заалтыг “Н.Г-т холбогдох хэргийг анхан шатны шүүхэд очтол шүүгдэгчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг “Хувийн баталгаа гаргах” таслан сэргийлэх арга хэмжээгээр сольж, түүнийг нэн даруй сулласугай” гэж өөрчилж, магадлалын тогтоох хэсгийн бусад заалтыг хэвээр үлдээсэн.
2.	Дээд шүүхийн тогтоол 2018.12.07 № 533	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 111 дүгээр шийтгэх тогтоол, Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 24 дүгээр магадлалыг хэвээр үлдээж, шүүгдэгч Х.Х, түүний өмгөөлөгч С.Алтай, Х.Бакен нарын хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлыг тус тус хэрэгсэхгүй болгосон.
3.	Дээд шүүхийн тогтоол 2019.03.06 № 108	ЧДЭХАШШ-ийн 2018.09.14-ний өдрийн 666-р шийтгэх тогтоол, Нийслэлийн ЭХДЗШШ-ийн 2018.12.06-ны өдрийн 1083-р магадлалд: ЭХТА-ийн 17.3 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч О.Т-г 20,000 нэгжээр торгох ял шийтгэж нэмэлт, өөрчлөлт оруулж, магадлалын залилах гэмт хэрэгтэй холбоотой заалтуудыг хүчингүй болгож, бусад заалтыг хэвээр үлдээсэн.
4.	Дээд шүүхийн тогтоол 2019.03.22 № 140	Налайх дүүргийн ЭХАШШ-ийн 2018.10.19-ний өдрийн 190-р шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэсэн Нийслэлийн ЭХДЗШШ-ийн 2018.12.20-ны өдрийн 1128-р магадлалыг хэвээр үлдээж, шүүгдэгч Ч.Х-гийн хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгосон.
5.	Дээд шүүхийн тогтоол 2020.02.05 № 69	Налайх дүүргийн ЭХАШШ-ийн 2019.08.14-ний өдрийн 111-р шийтгэх тогтоол, Нийслэлийн ЭХДЗШШ-ийн 2019.10.08-ны өдрийн 1001-р магадлалыг тус тус хүчингүй болгож, шүүгдэгч Ч.Х-д эрүүгийн хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр Налайх дүүргийн ЭХАШ-ны шүүхэд буцаасан.

Дээрх хүснэгтээс харвал Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүхээс 2017 оноос 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн байдлаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.7 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт холбогдох 5 магадлалыг хянажээ. Үүнээс магадлалыг өөрчилсөн 2, магадлалыг хэвээр үлдээсэн 2, магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхэд буцаасан 1 тохиолдол бүртгэгдсэн байна.

“Доктор Я.Батгэрэл 2024 онд Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 95 шийдвэр гүйцэтгэгчээс шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэж байсан эсэх талаар сонирхолтой судалгаа явуулсан” (Я.Батгэрэл, 2024, хууд. 134) байдаг.

№ Асуулт

1	Та шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгчид хариуцлага хүлээлгэж байсан уу?	Хүлээлгэж байгаагүй	1 удаа	2-4 удаа	5-аас дээш удаа
		41.1%	20%	27.4%	11.6%
№	Асуулт	Хариулт			
1	Төлбөр төлөгчид хариуцлага хүлээлгэхэд ажлын ачаалал хэр нөлөөлдөг вэ?	Ажлын ачаалал маш их	Их	Бага	Огт үгүй
		43.2%	37.9%	14.7%	4.2%

Уг судалгааны үр дүн бол иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэгч нар зөвхөн иргэний хэргийн шүүхээс гарсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дагнан хэрэгжүүлж чадахгүй өндөр ачаалалтай ажиллаж байгаатай шууд холбоотой юм.

Учир нь нэг шийдвэр гүйцэтгэгч иргэний хэргийн 8 төрлийн ажиллагааг хариуцан ажиллахаас гадна захиргааны хэргийн 4, зөрчлийн хэргийн 4, нийт 16 төрлийн шүүхийн шийдвэрт албадан гүйцэтгэх ажиллагаа явуулж байна. Олон төрлийн шийдвэрийг биелэлтийг хариуцаж байгаа шийдвэр гүйцэтгэгч нарын ажлын ачаалал өндөр байдаг нь төлбөр төлөгчид чиглэсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд хүндрэл дагуулж байдаг.

Дүгнэлт

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан, зайлсхийсэн төлбөр төлөгчид хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хуульд тусгасан байдлыг судлан үзэж дүгнэхэд ялын онол, үзэл баримтлалд нийцсэн. Харин төлбөр төлөгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас цагдаа, прокурорын байгууллагад хүсэлт, гомдол гаргасан тоон мэдээ тасралтгүй өссөн дүнтэй байна. Харин 2017 оноос хойших хугацаанд энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэлт шүүхийн шатанд шийдвэрлэхдээ 90 орчим хувьд нь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс төлбөр төлөгчийг буруутгаж шийдвэр гаргасан бол давж заалдах болон хяналтын шатны шүүхийн тогтоолоос харахад 80 хувь нь төлбөр төлөгчийг буруутгаж, анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээсэн байна.

Төлбөр төлөгчид шүүхээс эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн судалгаа хомс, шүүхийн шийдвэр бүр дээр нэг бүрчлэн уншиж судлан дүгнэлт хийхэд шүүхээс төлбөр төлөгчид эрүүгийн хариуцлагыг хүлээлгэж чадаж байгаа боловч цагдаа, прокурорын шатанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гаргасан хүсэлт үндэслэл муутай, нотлох баримт хангалтгүй байгаа зэрэг нь төлбөр төлөгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэж чадахгүйд хүрч байна. Цаашид шийдвэр гүйцэтгэгч нар ажлын ачааллаас үл хамааран төлбөр төлөгчид хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг эрчимжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ашигласан материал

1. бичиг, Т. (2015). *Шинжлэх ухааны тайлбар*. Уб.
2. сан, Ц. (2017-2025). <https://shuukh.mn/cases/1/1>. <https://shuukh.mn/>.-ээс Гаргасан
3. хүрээлэн, Х. з. (2021). *Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага сэдэвт судалгааны тайлан*. Уб.
4. Ц.Мөнхбат. (2020). *Нийтэд тустай ажил хийлгэх ял*. Уб.
5. Э.Хилгендорф, & Д, Ч. (2015). *Германы эрүүгийн эрх зүйн ерөнхий анги*. Уб.
6. эмхэтгэл, Т. м. (2015). *Монгол Улсын Эрүүгийн хууль*. Уб.
7. эмхэтгэл, Төрийн мэдээлэл. (1992). *Монгол Улсын Үндсэн хууль*. Уб.
8. эмхэтгэл, Төрийн мэдээлэл. (2002). *Монгол Улсын Иргэний хууль*. Уб.
9. эмхэтгэл, Төрийн мэдээлэл. (2017). *Монгол Улсын Прокурорын тухай хууль*. Уб.
10. эмхэтгэл, Төрийн мэдээлэл. (2017). *Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль*. Уб.
11. эмхэтгэл, Төрийн мэдээлэл. (2017). *Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль*. Уб.
12. эмхэтгэл, Төрийн мэдээлэл. (2021). *Монгол Улсын Шүүхийн тухай хууль*. Уб.
13. Я.Батгэрэл. (2024). *Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлага. Хууль сахиулахын докторын диссертаци*. Уб.